



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ
Б.НАРАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨ
(2017-2021)

(Шинэчлэн боловсруулав)

2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн ЭМХТ-ийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлав.

Улаанбаатар хот
2017 он

Боловсруулахад ашигласан материал:

1. Эрүүл мэндийн тухай хууль
2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
3. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль
4. МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
5. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
6. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /2017-2026/
7. “ЭМХТ-ийн 2015-2019 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”
8. Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаал

ӨМНӨХ ҮГ



Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлагдаж 10 жилийн хугацааны хөгжлийн ерөнхий зураглал, төлөв тодорхойлогдсон энэ цаг үед тус байгууллага хөгжлийнхөө 20 жилийг туулж, дараагийн шинэ үед хөл тавин тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтоо тодорхойлоод байна.

Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай” 2012 оны 50, Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2015 оны 376 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” А/203 дугаар тушаалаар шинэчлэн зохион байгуулагдаж шинэ бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажиллаж байгаа хэдий ч, 21 жилийн хөгжлийн түүхэн замналыг туулсан арвин туршлагатай байгууллага юм.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, байгууллага, хүний нөөц, техник технологи, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага билээ.

Манай хамт олон эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэлийн түүхийг хамтран бүтээлцэж, хүн ардынхаа эрүүл энхийн төлөө, мэдлэг, оюун, сэтгэл зүтгэл, цаг хугацаагаа зориулан ажиллана гэдгээ тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Стратегийн энэхүү төлөвлөгөө нь түүхэн ололт амжилтдаа тулгуурлан төрөөс олгогдсон чиг үүргийн хүрээнд салбарын хөгжилд зохих хувь нэмрээ оруулах бүтээлч зорилгодоо хүрэх үндсэн удирдамж, гол хөтөч байх болно.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙГ 2021 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ, ЕРӨНХИЙ ЗОРИЛГО

Тодорхойлолт

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн салбарын хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр, стратеги, дүрэм, журам, стандарт, удирдамжийг боловсруулахад шаардлагатай бодлогын судалгаа хийх, сургалт явуулах, шийдвэр гаргагчдыг нотолгоо, статистик тоо, мэдээллээр хангах, холбогдох хууль, тогтоомж, сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэл, эрүүл мэндийн ажилтны хөгжил, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, салбарын зайн анагаах ухаан, мэдээллийн технологи, эрүүл мэндийн удирдлага, хөгжлийн асуудалтай холбоотой бодлогын хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага мөн.

Алсын хараа: *Оновчтой шийдэл-Эрчимтэй хөгжил*

Эрхэм зорилго

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, байгууллага, хүний нөөц, техник технологи, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

Стратегийн тэргүүлэх чиглэлүүд

Бид зорьж буй алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах стратегийн чиглэлийг тэргүүлэх ач холбогдолтой хэмээн тодорхойлж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааг хөгжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх;
2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулж олон улсын болон бүсийн жишигт нийцүүлэх;
3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрх зүй, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг цахимжуулах замаар удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

5. Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх;
6. Эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэх;
7. Байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах;

Үнэт зүйлс

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамт олны гишүүн бүр дараах үнэт зүйлсийг эрхэмлэн, дагаж мөрдөнө. Үүнд:

- Төрийн үйлчилгээ нь чанартай, шуурхай, ээлтэй байх
- Өндөр мэргэшсэн, чадварлаг хүний нөөцтэй байх
- Хууль тогтоомжийг сахиж, хариуцлагатай, ил тод байх
- Нэгдмэл үйл ажиллагаа, баг, удирдлагатай байх
- Оновчтой хөрөнгө оруулалт, мэдрэмжтэй хуваарилалттай байх
- Эрх тэгш, нээлттэй, сайн түншлэлтэй байх
- Үйл ажиллагаа нь тогтвортой, үр дүнтэй, үр ашигтай байх
- Байгууллагын соёл, үнэт зүйл, ёс зүйг эрхэмлэдэг байх

АЖИЛЛАХ ЗАРЧИМ:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцыг чанд сахих
- Ил тод, нээлттэй, авлигаас ангид ажиллах
- Төрийн албан хаагчийн ёс зүй, хуулийг мөрдлөг болгох

**СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ**

ЭМХТ-ийг 2021 он хүртэл хөгжүүлэх үндсэн 7 стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойллоо.

- Эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааг хөгжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх;
- Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулж олон улсын болон бүсийн жишигт нийцүүлэх;
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрхзүй, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх;
- Эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэх;
- Байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах;

Тэргүүлэх чиглэл 1. Эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааг хөгжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх

Стратегийн зорилго 1.

Эрүүл мэндийн салбарын бодлого, тогтолцооны судалгааг өргөжүүлэн хөгжүүлэх, үндэсний тооцоо, технологийн үнэлгээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, төслийн хэрэгжилтийг үнэлэх, шийдвэр гаргагчдыг чанартай мэдээ, мэдээллээр хангах

Зорилт 1.1. Бодлого, шийдвэрийн нотолгоо, мэдээллийн чанарыг сайжруулах

Хэрэгжүүлэх стратеги 1	Хэмжих үзүүлэлт
Нийт мэргэжилтэнд эзлэх судлаач мэргэжилтний хувийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Мэргэжилтний 30 хувиас доошгүй нь салбарын хэмжээний судалгааны багт хамтран ажилласан байх ▪ Эрдмийн зэрэгтэй ажилтны тоо 2-

	<p>оос доошгүй нэмэгдсэн байх</p> <ul style="list-style-type: none"> ▪ Дотоодын болон олон улсын сэтгүүлд бүтээлээ хэвлүүлдэг мэргэжилтний тоо жилд 2-оос доошгүй байх ▪ Мэргэжилтний 30 хувиас доошгүй нь салбарын хэмжээний болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж оролцсон байх.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Судалгаанд зориулсан албан ёсны лицензтэй програмуудын хүртээмж, хангамжийг нэмэгдүүлж, судалгааны эх сурвалжуудын хамрах хүрээг өргөжүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Судалгааны програм хангамж болон эх сурвалжуудыг худалдан авахад ЭМХТ-ийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрдэм шинжилгээний зардлын 5 хувиас доошгүйг зарцуулах
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, байгууллага, эвсэлийн үйл ажиллагааг ЭМХТ-ийн судалгааны үр дүнг нэмдэгдүүлэхэд ашиглах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Мэргэжлийн нийгэмлэг, байгууллагатай хамтарч ажиллах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
<p>Хэрэгжүүлэх стратеги 4</p> <p>Байгууллагын захиалгат судалгаа, бодлогын судалгаа, төсөл, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ 15 сая төгрөгөөс дээш дүнтэй байгууллагын захиалгат болоод бодлогын судалгааны тоог 2-т хүргэх ▪ Судалгааг дэмжих сан байгуулах

Зорилт 1.2. Эрүүл мэндийн үндэсний тооцоо, эдийн засгийн дүн шинжилгээг тогтворжуулах

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийн болон ажлын залгамж холбоог алдагдуулахгүй байх зохион байгуулалтын бүтцийн</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд бүхий зохион байгуулалтын бүтэц бий болж тоо нэмэгдсэн байна.
---	---

тогтвортой байдлыг хангах	
Хэрэгжүүлэх стратеги 2 ЭМҮТ-ны үзүүлэлтүүдийг гаргахад зайлшгүй шаардлагатай судалгаануудын жагсаалтыг гаргаж, тогтмол, тодорхой давтамжтайгаар хийх ажлыг зохион байгуулах	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Шаардлагатай судалгаанууд тогтмол, тодорхой давтамжтайгаар хийгдэж үр дүнгийн тайлангийн тоо нэмэгдсэн байна.
Хэрэгжүүлэх стратеги 3 ЭМҮТ, эдийн засгийн дүн шинжилгээ хариуцсан нэгжийн техникийн болон ур чадварыг тогтмол нэмэгдүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд орчин үеийн тооцооллын техник хэрэгсэлээр хангагдаж, чадавхжсан мэргэжилтнүүдийн тоо нэмэгдсэн байна.
Хэрэгжүүлэх стратеги 4 Бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдад ЭМҮТ-ны үр дүнг хэрхэн ашиглах талаар сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчид ЭМҮТ-ны үр дүнг хэрхэн ашиглах талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.
Хэрэгжүүлэх стратеги 5 Мэдээллийн бүхий л эх үүсвэрүүдээс холбогдох мэдээллүүдийг цуглуулж мэдээллийн нэгдсэн сан үүсгэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ ЭМҮТ-ны мэдээллийн сан бүрдсэн байна.

Зорилт 1.3. Эрүүл мэндийн салбарын хөгжил, удирдлага, технологийн ахиц дэвшил, бодлого боловсруулалт, эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн олон талт асуудлын хүрээн дэх ЭМХТ-ийн нөлөөллийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх стратеги 1 Бодлогын судалгаа явуулдаг олон улсын ба дотоодын хүрээлэн төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, ажлын уялдаа холбоог бэхжүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Бодлогын судалгаа явуулдаг олон улсын болон дотоодын хүрээлэн, төвүүдтэй хамтын ажиллагааны гэрээ, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо, чанар, хамтран ажиллагч байгууллагын тоо өссөн байна.
Хэрэгжүүлэх стратеги 2 Эрүүл мэндийн салбарын хэрэгцээ, шаардлагад үндэслэн тодорхой	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг баримт,

чиглэлээр бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх	нотолгоогоор хангасан судалгааны тайлангийн тоог өсгөх
Хэрэгжүүлэх стратеги 3 Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоог бэхжүүлэн, тогтворжуулах	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Сургалтын хэрэгцээ тодорхой болсон байна. ▪ Сургалтын журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна. ▪ Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ▪ Удирдах ажилтны сургалтын тогтолцоог бүрдүүлэх.
Хэрэгжүүлэх стратеги 4 Эрүүл мэндийн салбарын төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийх аргачлал батлуулан, үнэлгээ хийх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Үнэлгээ хийх батлагдсан аргачлал, Үнэлгээний тайлан, танилцуулсан байдал, гарсан шийдвэр

Тэргүүлэх чиглэл 2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулж олон улсын болон бүсийн жишигт нийцүүлэх

Энэхүү тэргүүлэх чиглэлийн зорилго нь Монгол улсын хүн амын эрүүл мэндийн мэдээллийн төрөл, агуулга, чанарыг сайжруулж мэдээллийн технологи, зайн анагаах ухааныг хөгжүүлэх замаар нотолгоонд суурилсан мэдээллээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг хангаж эрүүл мэндийн салбарын удирдлагын мэдээллийн тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Зорилт 2.1. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг сайжруулах

Хэрэгжүүлэх стратеги 1 Эрүүл мэндийн салбарын энтерпрайз архитектурыг үндэсний энтерпрайз архитектурт нийцүүлэн боловсруулж нэвтрүүлэх	Хэмжих үзүүлэлт Энтерпрайз архитектур болон харилцан үйлчлэлийн тогтолцоог хөгжүүлэх <ul style="list-style-type: none"> ▪ Бизнес архитектур ▪ Өгөгдлийн архитектур ▪ Хэрэглээний архитектур ▪ Технологийн архитектурууд боловсруулагдана.
--	---

<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эрүүл мэндийн мэдээллийн олон улсын стандартыг нэвтрүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Олон улсын HL7 стандартыг Монгол улсад нэвтрүүлсэн байна.

Зорилт 2.2. Эрүүл мэндийн статистик мэдээллийн төрөл, агуулгыг боловсронгуй болгож чанарыг сайжруулах

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Үндэсний түвшинд тооцох эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлалыг олон улсын аргачлалд нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэн олон улсын болон бүсийн жишигт нийцүүлэн боловсруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн батлуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эрүүл мэндийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлүүдийг олон улсын түвшинд нийцүүлэн боловсруулж гаргах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн сар, улирал, жилийн статистикийн үзүүлэлтүүдийн эмхэтгэлийн агуулга шинэчлэгдэж олон улсын түвшинд хүрсэн байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Эрүүл мэндийн мэдээний бүртгэл, тайлангийн маягыг өөрчлөлт, хөгжилтэй нийцүүлэн тогтмол шинэчлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн мэдээний бүртгэлийн маягыг ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөлөөр батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. ▪ Батлагдсан маягыг ном болгон хэвлүүлэх, түгээн тарааж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 4</p> <p>Health-Info програм хангамжийн шинэчилсэн хувилбарыг боловсруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Статистикийн модулийг хөгжүүлэн олон улсын түвшинд хүргэх
<p>Хэрэгжүүлэх стратеги 5</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p>

Health-Info програм хангамжийг бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> Програмыг нэвтрүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх
Хэрэгжүүлэх стратеги 6 Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн цахим хуудас ажиллуулах	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Хүн амын эрүүл мэндийн мэдээ мэдээллийг олон нийт мэдээлэл хэрэглэгчдэд хүргэх цахим хуудсыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх
Хэрэгжүүлэх стратеги 7 Цахим шалгалтын үйл ажиллагааг өргөжүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Цахим шалгалтын техник, тоног төхөөрөмжийн тоо, хүчин чадал, шалгалтанд хамрагдагсдын тоо нэмэгдсэн байна.

Зорилт 2.3. Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх, зайн сургалтыг өргөжүүлэх

Хэрэгжүүлэх стратеги 1 Эрүүл мэндийн байгууллагуудыг телемедицин үндэсний сүлжээнд холбох	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Идэвхитэй ба идэвхигүй телемедицин сүлжээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг холбох
Хэрэгжүүлэх стратеги 2 Дүрс дамжуулах, хадгалах PACS системийг нэвтрүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> II болон III шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад PACS системийг нэвтрүүлэх
Хэрэгжүүлэх стратеги 3 Эрүүл мэндийн ажилтны зайн сургалтыг өргөжүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн ажилтнуудыг ажлын байран дээр чадавхижуулах зайн сургалтын төв байгуулах

Зорилт 2.4. Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн үзүүлэлтийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох чадавхийг бэхжүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн мэргэжилтнийг чадавхижуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн статистикч их, бага эмч нар болон мэдээллийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах ▪ Өвчний олон улсын X ангилал, үйлдлийн олон улсын IX ангиллын сургалтыг тогтмол зохион байгуулах
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эрүүл мэндийн мэдээллийн технологи, телемедициний мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтын хэрэгцээг тооцон танхимын болон зайн сургалтыг зохион байгуулах

Тэргүүлэх чиглэл 3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрх зүй, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх

Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн талаарх хууль эрхзүйн орчинг бүрдүүлж, түүний зохицуулалтыг олон улсын жишигт хүргэснээр эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагаа хангах нөхцөл сайжирна.

Мөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалт, засвар тохируулга–үйлчилгээний тогтолцоог бий болгож, эрүүл мэндийн салбарын хэмжлийн нэгдмэл байдал хангагдсанаар эмчилгээ, оношилгооны чанарт ахиц гарна.

Эмнэлгийн инженер, техникчдэд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нарийн мэргэжлээр төрөлжүүлэх, мэргэжлийн зэрэг дэв олгох, төгсөлтийн дараах болон тасралтгүй сургалтыг нэгдсэн зохион байгуулалтад оруулан инженер техникийн ажилтны ур чадвар, өсөн дэвших, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, салбарын хэмжээний техник технологийн чадварлаг мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлнэ.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэршил ангиллыг нэвтрүүлж, бүртгэл, мэдээллийн сангийн програм хангамжийг нэвтрүүлж эмнэлгийн тоног төхөөрөмжийн, сэлбэг хэрэгслийн хэрэгцээ шаардлагын судалгаа, тооцоолол, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, оновчтой хуваарилалт, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалтын статистик тоо мэдээ болон бусад мэдээллийг нэг дороос авах нөхцөл бололцоог бий болгоно.

Зорилт 3.1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрх зүйн орчин бүрдүүлж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжилтний сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хууль эрх зүй, зохицуулалтын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хуульд эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлээр зүйл заалт тусгагдсан байна. ▪ Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөх эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт, холбогдох журам, боловсруулагдсан байна. ▪ Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үнэлгээ хийх, арга аргачлал, шалгуур үзүүлэлтийг сайжруулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын эрх зүйн орчинг сайжруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалттай холбоотой дүрэм, журам батлагдсан байна. ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын арга аргачлал боловсруулагдсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжилтэнийг сургах, мэргэжлийн удирдлагаар хангах, чадавхижуулах ажлыг нэгдсэн зохицуулалтаар хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчдийн сургалтын хэрэгцээ шаардлага тодорхойлогдсон байна. ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалтын зохион байгуулалт

	<p>сайжирсан байна</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч, эмч, мэргэжилтнүүдэд ашиглалт, аюулгүй ажиллагаа болон мэргэшүүлэх, мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулагдсан байна.
--	--

Зорилт 3.2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, засвар тохируулга, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эрүүл мэндийн салбарын оношилгоо, эмчилгээнд ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт баталгаажуулалтын ажлыг зохион байгуулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн салбарт ашигладаг тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтад хамруулсан тоног төхөөрөмжийн тоо болон нэр төрлийг нэмэгдүүлсэн байна . ▪ Олон улсын жишигт нийцсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын лабораторитой болсон байна. ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалт хийгдэж, гэрчилгээ олгогдсон байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тогтолцоог сайжруулах, холбогдох баримт бичиг, журам боловсруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын дараах засвар тохируулга хийх ажлыг зохион байгуулагдана. ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зохицуулалттай бий болно.
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн нэгдсэн тооцоо болон хэрэгцээний судалгаа хийх, мэдээллээр хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн тооцоо судалгаа хийгдсэн байна. ▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсөв санхүү тодорхойлогдоно.

Зорилт 3.3. Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц, эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц, агааржуулалт, газардуулга, цахилгаан</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэцийн судалгаа хийгдсэн
--	---

хангамж, эмнэлгийн хийн хангамжийн тооцоо судалгаа хийх, нэгдсэн арга зүйгээр хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх	байна. <ul style="list-style-type: none"> Шийдвэр гаргагч болон холбогдох байгууллагууд судалгааны мэдээллээр хангагдана.
Хэрэгжүүлэх стратеги 2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл, нэршил, ангиллыг олон улсын стандартын дагуу бий болгох	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэршил ангилал нэвтэрсэн байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн програм хангамж нэвтрүүлсэн байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн тогтолцоо нэвтэрсэн байна.
Хэрэгжүүлэх стратеги 3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгаа, тооцоог өвчний онош эмчилгээний үр дүн, эдийн засгийн үр ашгийг тооцоолох	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн клиникийн үр ашиг тооцоо хийгдэнэ. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээний үнэлгээ хийгдэнэ. Шинэ дэвшилтэт техник, технологийн судалгаа хийгдэнэ.

Тэргүүлэх чиглэл 4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох;

Зорилго: Хүний нөөцийн хөгжил, төгсөлтийн дараах сургалтын тогтолцооны цахим орчинг боловсронгуй болгох.

Зорилт 4.1. Зайн сургалтыг алслагдсан орон нутгийн эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд өргөнөөр ашиглах

Хэрэгжүүлэх стратеги 1 Эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан зайн сургалтын нэгдсэн платформ бий болгож, үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Зайн сургалтын нэгдсэн платформ үйл ажиллагаанд нэвтэрсэн байна.
Хэрэгжүүлэх стратеги 2 Салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны шаардлага хэрэгцээнд бүрэн нийцсэн салбарын хүний нөөцийн хөгжил, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх,

	мэдээллийг шинэчлэх, ашиглах журмыг боловсруулан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.
--	---

Зорилго: Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийг дэмжих үйл ажиллагааны арга зүйг боловсронгуй болгох

Зорилт 4.2. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зохион байгуулалтыг сайжруулах

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын эрх зүйн орчинг өөрчлөх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын зохицуулалттай холбоотой журмыг шинэчлэн батлуулсан байна. ▪ Төгсөлтийн дараахь сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, зардлын жишиг, сургалтын тэтгэлэг олгох шалгуур, тэтгэлгийн хэмжээ, зардлын жишгийг өөрчлөн боловсруулж Сангийн болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Жилд 3-аас доошгүй сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлж, шинэчилсэн байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг өөрчлөх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 4</p> <p>Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт үндсэн мэргэшлийн сургалт явуулах орчин нөхцлийн бүрдүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч нарыг эмнэл зүйн сургагч багшийн сургалтанд хамруулах ▪ Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ОУБ-тай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, эмч мэргэжилтнийг чадавхижуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 5</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p>

<p>Төгсөлтийн дараах сургалтад хамрагдагсдын (дотоод, гадаад) мэдлэг, ур чадварыг сорих онол практикийн бага хурал зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгон, тогтмолжуулах</p>	<ul style="list-style-type: none"> ▪ ТДС-д суралцагчдын дунд эрдэм шинжилгээ, судалгааны онол практикийн бага хурлыг жилд 1 удаа зохион байгуулдаг болсон байна. ▪ Мэдлэг, ур чадварын уралдаан, тэмцээнийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулдаг болсон байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 6</p> <p>Ерөнхий мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хөтөлбөр батлагдаж, сургалт эхэлсэн байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 7</p> <p>Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, эмнэлзүйн сургагч багшийг үе шаттайгаар бэлтгэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх төлөвлөгөө батлагдаж, сургалтыг зохион байгуулж эхэлсэн байна.

Зорилго: Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох

Зорилт 4.3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлж, боловсронгуй болгох

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох асуудлын эрх зүйн орчинг өөрчлөх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын төслийг боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байна. ▪ Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар, холбогдох маягтыг өөрчлөн боловсруулж батлуулсан байна. ▪ Эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой зардлын жишгийг өөрчлөн боловсруулж Сангийн болон Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p>

<p>Эмнэлгийн мэргэжилтний (дотоод, гадаад, орон нутаг) мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Гадаадын эмнэлгийн мэргэжилтнээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах сорилын цахим сантай болсон байна. ▪ Гадаадын эмнэлгийн мэргэжилтнээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг 2019 оноос цахимаар авдаг болсон байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн цахим шалгалтын салбар төвийг орон нутагт байгуулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Аймаг, орон нутгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ-тэй хамтран бүсийн төвүүдэд цахим шалгалтын салбар төвийг байгуулсан байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 4</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалт авах сорилын (гадаад, дотоод) чанарт шинэчлэл хийх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Шалгалтын сорилын чанарт үнэлгээ хийх, ▪ Сорилын чанарыг олон улсын түвшинд хүргэхэд сорил боловсруулах багийг чадавхижуулах ▪ Сорилын баяжилтыг тогтмол хийх ▪ Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын сан үүсгэх, баяжилтыг хангах

Зорилт 4.4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр шинэчлэл хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал, норм нормативийг тогтоох чиглэлээр судалгаа хийж санал боловсруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ ЭМЯ, ХЯ, МЭМАҮЭХ зэрэг байгууллагатай хамтран эрүүл мэндийн ажилтны ажлын ачааллын судалгаа хийсэн байна. ▪ Эмч, эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, нормативын талаар санал боловсруулж холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн байна. ▪ Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна.
---	---

Тэргүүлэх чиглэл 5. Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх

Зорилт 5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжиж буй тушаал, дүрэм, журам шинэчлэгдсэн байна. ▪ ЭМБ нь ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд ЧАБ-н шалгууруудыг тооцдог болсон байна. ▪ ЧАБ-ын Benchmark үзүүлэлтүүдийг тодорхойлж үнэлгээнд ашиглаж хэвшсэн байна. ▪ Асуудалд чиглэсэн чанар-аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг салбарын, бүс нутгийн, байгууллагын, тасаг нэгжийн, хувь хүний болон хөтөлбөрийн түвшинд боловсруулж тогтмол хянахад эрүүл мэндийн байгууллагыг арга зүйн удирдлагаар ханган ажилладаг болсон байна. ▪ ЭМЯ, ЭМГ, байгууллагын Эрсдэлийн хорооны бүтэц, чиг үүргийн тухай ЭМС-ын тушаалаар үлгэрчилсэн журам гарч ЭМБ хэрэгжүүлж эхэлсэн байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын мэдээ, мэдээллийн бүртгэл, хэрэглээг сайжруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрсдэлийн үнэлгээ хийх загвар аргачлалыг шинэчлэн боловсруулснаар эрүүл мэндийн байгууллагууд загвар аргачлалын дагуу эрсдэлийн үнэлгээг хийдэг болсон байна ▪ Үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлын өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийгдэж, авах арга хэмжээний санал тодорхой болсон байна.

	<ul style="list-style-type: none"> ▪ Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн стандарт үлгэрчилсэн асуумж боловсрогдсон байна. ▪ Удирдлагын бүх түвшин эргэн мэдээлэх сувгуудыг ЭМБ бүр 2-аас цөөнгүй сувгийг бүрдүүлсэн байна. ▪ Эрүүл мэндийн байгууллагуудын сайн туршлага, алдаа зөрчлийн мэдээллийг цуглуулах цахим сантай болсон байна Эрүүл мэндийн байгууллагуудад бүртгэгдсэн алдаа зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийн, мэдээний чанар, сайжирсан байна. ▪ Алдаа зөрчлийн мэдээг бүртгэх, дүгнэлт хийж, эргэн мэдээлэх журам шинэчлэгдсэн байна.
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ ЭМБ-ууд ноцтой тохиолдлуудад RCA шинжилгээг 100% хийж хэвшсэн байна. ▪ ЧАБ-н үндэсний сургагч багш нар бэлтгэгдсэн байна. ▪ Шинээр ажилд авсан ажилтнуудаа Чиглүүлэх сургалтанд сургадаг болоход ЭМС-ын тушаалаар үлгэрчилсэн журам батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна. ▪ Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагыг сайжруулах сургалт зохион байгуулах ЭМЯ-ЭТГ, Чанарын албаны гишүүдийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна.

Зорилт 5.2. Эрүүл мэндийн байгууллагуудад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох эрх зүйн орчныг шинэчлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, журамд өөрчлөлт орсон байна. ▪ Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. ▪ Магадлан итгэмжлэх шинжээч сонгон шалгаруулах, ажлуулах журамд
--	---

	<p>өөрчлөлт орсон байна.</p> <ul style="list-style-type: none"> Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад явцын ХШҮ хийх журам, шалгуур үзүүлэлт шинэчлэгдсэн байна
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Бүх түвшний эрүүл мэндийн байгууллагууд, магадлан итгэмжлэлийн үндэсний шинжээчдийн чадамжийг дээшлүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> Магадлан итгэмжлэлийн өмнөх болон дараах сургалтыг бүх түвшний эрүүл мэндийн байгууллагуудад зохион байгуулж, ЭМБ чадавхижсан байна. Магадлан итгэмжлэлийн шинжээчдэд зориулсан сургалтыг зохион байгуулан, шинжээчдийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна. Эрүүл мэндийн байгууллага, магадлан итгэмжлэлийн шинжээчдэд арга зүйн гарын авлагаар хангагдсан байна

Тэргүүлэх чиглэл 6. Эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэх

Энэхүү тэргүүлэх чиглэлийн зорилго нь эмийн бүртгэл, эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, эмийн бүртгэлийн дараах чанар, аюулгүй байдлын тандалт судалгааг сайжруулах замаар Монгол улсын эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэн, хүн ам болон эм зүйн тусламж үйлчилгээнд аюулгүй, чанарын баталгаатай эм хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх, боломжийн үнэтэй эмийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

Зорилт 6.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг боловсронгуй болгох

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эмийн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> 8 шинжээчийг бүртгэлийн материалд үнэлгээ хийх чиглэлээр гадаадын сургалтад хамруулах Бүртгэлийн үйл ажиллагааны стандарт ажиллагааны заавартай болох
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эмийн бүртгэлийн мэдээний сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> Эмийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах

Зорилт 6.2. Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт экспортын лиценз олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Импорт, экспортын лиценз олгох эрх зүйн орчныг сайжруулж, цахимжуулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журмыг шинэчлэн батлуулах ▪ Лицензийг цахимаар олгодог болох
---	--

Зорилт 6.3. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эмийн мэдээлэл, зах зээлд таниулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, олон талт оролцоог хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмийн зохистой хэрэглээний сургагч багш бэлтгэж, олон талт оролцоог хангах ▪ Антибиотикийн зохистой хэрэглээний сургалт, сурталчилгааг орон даяар явуулах ▪ Бүртгэлтэй эмийн Лайсмед програмын гар утасны аппликэйшн бий болгох
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эмийн жор бичих, жороор олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмийн жор бичилтийн стандартын хэрэгжилтэд 2 удаа үнэлгээ хийж, сургалт явуулах ▪ Нийслэлд цахим жор бичилтийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2 удаагийн сургалт явуулах
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг боловсронгуй болгох</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээж буй эмийн мэдээлэл, зар сурталчилгаанд 2 удаа үнэлгээ хийх ▪ Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааны гарын авлага

	боловсруулж, түгээх
<p>Хэрэгжүүлэх стратеги 4</p> <p>Эмнэлзүйн эмзүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалд тохируулан үе шаттайгаар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээнд үнэлгээ хийх ▪ Эмийн эмчилгээг зохицуулах хорооны журамд өөрчлөлт оруулах ▪ Эмнэлзүйн эм зүйн чиглэлээр олон улсын зөвлөх ажиллуулах

Зорилт 6.4. Эмийн зах зээлд гарсны дараах чанар аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгож, эрчимжүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эмийн чанар, аюулгүй байдлын цахим мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх, тогтвортой байдлыг хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Эмийн бүртгэл, мэдээллийн Лайсмед мэдээний санг Эмийн чанар, аюулгүй байдлын цахим мэдээллийн тогтолцоотой холбох
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Эмийн зах зээлийн дараах тандалт судалгааны үйл ажиллагааг боловсронгуй болгож, эрчимжүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагууд өөрийн бүтээгдэхүүний аюулгүй байдалд тандалт судалгаа хийх тогтолцоог бий болгох талаар журамд өөрчлөлт оруулах ▪ Олон нэрээр бүртгэгдсэн эмийн тандалт судалгаа хийх ▪ Дотоодын эмийн үйлдвэрийн эмийн чанар, аюулгүй байдалд тандалт судалгаа хийх
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Эмийн гаж нөлөөний бүртгэн мэдээлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, Олон улсын Эмийн хяналтын төвийн жинхэнэ гишүүн болох</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийг цахимжуулах ▪ Олон улсын Эмийн хяналтын төвийн жинхэнэ гишүүн болох ▪ Иргэдэд чиглэсэн эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл,

	сурталчилгааг явуулах
--	-----------------------

Зорилт 6.5. Эм зүйн тусламж үйлчилгээний зохистой дадлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эм хангамжийн байгууллагын болон эмийн бусад зохистой дадлын хяналт-үнэлгээг хэрэгжүүлэх, мэдээний сан бүрдүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Үндэсний эмийн үйлдвэрүүдэд Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын хяналт үнэлгээ хийх
--	--

Зорилт 6.6. Эмийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, төрөөс зайлшгүй шаардлагатай эмийн үнийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Эмийн хангамж, хүртээмж, үнийн талаарх мэдээний сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Үндэсний үйлдвэрийн болон импортын нянгийн эсрэг эмийн хангамжийн судалгаа хийх ▪ Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, үнийн талаарх мэдээний сан үүсгэх
---	---

Зорилт 6.7. Эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Тусгай зөвшөөрөлтэй эм хангамжийн байгууллагуудын мэдээний сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр нэр төрлийн судалгаа хийх
--	---

Тэргүүлэх чиглэл 7. Байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах

Энэхүү тэргүүлэх чиглэлийн зорилго нь ЭМХТ-ийн бие даасан, тогтвортой байдлыг хангах, байгууллагын бүтэц, үйл ажиллагааг оновчтой болгох, улмаар салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгыг биелүүлэхэд дэмжих нөөц хуваарилалтын сайн тогтолцоо, санхүүгийн тогтвортой олон эх үүсвэр, гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бий болгоход оршино.

Зорилт 7.1. Байгууллагын бие даасан, тогтвортой байдал, бүтцийг боловсронгуй болгох

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>ЭМХТ-ийн бие даасан, тогтвортой бүтцийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эрүүл мэндийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжид ЭМХТ-ийн статусыг тодорхой болгох, хэрэгжүүлж буй чиг үүргүүдийг хуульчилж, холбогдох зүйл заалтад тусгуулах
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>ЭМХТ-ийн бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг оновчтой болгох</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Зохион байгуулалтын шинэ бүтэц ба ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн батлах
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Жилийн төлөвлөлт, төсөвлөлтийг боловсронгуй болгох, нөөц хуваарилалтын тогтолцоог сайжруулах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Жилийн төлөвлөлт, төсөв, төсвийн төсөөллийг боловсруулах ▪ Төсөв, төлөвлөлтийн системийг бий болгох / төсөв, төлөвлөлтийн програм/
<p>Хэрэгжүүлэх стратеги 4</p> <p>Хүний нөөцийн сургалтын болон нийгмийн баталгааг хангах бодлого, хөтөлбөрийг шинэчлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Холбогдох бодлого, хөтөлбөрийг гаргах ▪ Хамтын гэрээ, дотоод журмыг шинэчлэх ▪ Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг оновчтой болгох ▪ Үйл ажиллагааны үр дүн, чанарт тохирсон урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх ▪ Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж, судалгаанд тулгуурласан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх

Зорилт 7.2. Байгууллагын үйл ажиллагааг цахим системд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим системд нэвтрүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Архив, албан хэрэг хөтлөлтийн програмыг шинэчлэх ▪ ЭМХТ-ийн архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх ▪ ERP системтэй болох
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Архивын өрөө тасалгааг өргөжүүлэх, зориулалтын шүүгээгээр хангах</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ ЭМХТ-ийн архивын өрөө, зориулалтын шүүгээний тоог нэмэгдүүлэх
<p>Хэрэгжүүлэх стратеги 3</p> <p>Дотуур байранд орох хүсэлт болон сонголтыг цахим системд нэвтрүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Програм хангамжийг бий болгон ашиглалтад оруулах ▪ Байранд орох өргөдлийг цахимаар бүртгэдэг болсон байна. ▪ Байранд орох эмнэлгийн мэргэжилтнийг цахимаар сонгодог болсон байна.

Зорилт 7.3. Санхүүжилтийн тогтвортой олон эх үүсвэрийг бий болгох

<p>Хэрэгжүүлэх стратеги 1</p> <p>Улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Төсвийн санхүүжилтийг үйл ажиллагааны өргөжилт, хэрэгцээ шаардлагад үндэслэн тооцоолж жилд 20-иос доошгүй хувиар нэмэгдүүлэх
<p>Хэрэгжүүлэх стратеги 2</p> <p>Хувийн хэвшил, олон улсын ба төрийн бус байгууллагатай төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах / хүний нөөцөө чадавхижуулах, сургалт, судалгаа хийх, лаборатори, тоног</p>	<p>Хэмжих үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хамтран ажилладаг дотоодын болон ОУ-ын байгууллагуудын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлж хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг чанартай

төхөөрөмж, ном зэрэг дэмжлэг авах/	гүйцэтгэн тайланг хүргүүлж дараагийн жилүүдэд хэрэгжүүлэх төслийн саналуудыг хүргүүлж дэмжлэг авах
Хэрэгжүүлэх стратеги 3 Өөрийн үйл ажиллагааны бусад орлогыг нэмэгдүүлэх /шалгалт, бүртгэлийн хураамж, төлбөртэй сургалт, сертификаттай сургалт, семинар, зөвлөгөө өгөх үйлчилгээ, түрээс зэрэг/	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Тухайн жилийн батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхаарч орлого бүрдүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх

Зорилт 7.4. Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтад суралцах хугацаанд амьдрах дотуур байрны орчин, хангамж, үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах

Хэрэгжүүлэх стратеги 1 ЭМХТ-ийн 2-р байранд урсгал засвар хийх / цахилгааны монтаж, сантехник, барилгын дотоод, гадна засвар/	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Урсгал засварын төсвийг жил бүрийн улсын төсөвт батлуулах ▪ Засварын ажлуудыг цаг хугацаанд нь хийж дотуур байрны амьдрах орчинг сайжруулах
Хэрэгжүүлэх стратеги 2 ЭМХТ-ийн 2-р байрны байрлагсдад зориулсан үйлчилгээг нэмэгдүүлэх	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Номын сан, интернетийн үйлчилгээг тогтмолжуулах
Хэрэгжүүлэх стратеги 3 Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, мэдээлэл, сургалт, үйлдвэрлэл, ШУ, эрдэм шинжилгээ, судалгаа, техник, технологийн ордон барих асуудал	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Улсын төсөвт энэхүү ордон барих зураг төсөв, ТЭЗҮ хийх зардлыг тусгах ▪ Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх

Зорилт 7.5. Мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх

Хэрэгжүүлэх стратеги 1 Эрүүл мэндийн салбарт бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг сурталчлах, ололт амжилт, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн төв байгуулах	Хэмжих үзүүлэлт <ul style="list-style-type: none"> ▪ Хэвлэл мэдээллийн төв байгуулах, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлүүлэх ▪ Хэвлэлийн бага хурлыг цахимаар орон нутаг болон дүүргийн ЭМТ-дэд шууд хүргэх
--	--

